



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН
ЗАРДЛЫН ТООЦОО**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2023

Улаанбаатар хот

Судалгааг хянасан:

Г.Давааням

Эрдэмтэн нарийн бичгийн дарга
Хууль зүйн ухааны доктор (LL.D.)

Судалгааг удирдсан:

Б.Түмэндэмбэрэл

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)

Судалгааг гүйцэтгэсэн:

Э.Сэлэнгэ

Эрдэм шинжилгээний ажилтан

С.Мягмарсүрэн

Эрдэм шинжилгээний ажилтан

Агуулга

I УДИРТГАЛ.....	3
II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	4
2.1. УИХ-ын гишүүдийн тоог нэмэхтэй холбоотой гарах зардал	4
2.1.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох	5
2.1.2. Хүний нөөцийг тодорхойлох	5
2.1.3. Гарах зардлыг урьдчилан тооцох	8
2.1.4. Үр дүнг тооцох	9
2.2. Үндсэн хуулийн цэц хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын тооцоо	11
2.2.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох	11
2.2.2. Хүний нөөцийг тодорхойлох	12
2.2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох	17
2.2.4. Үр дүнг тооцох	18
2.2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах	19
III ДҮГНЭЛТ, САНАЛ.....	20

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

/ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ/

I УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцож, холбогдох зардлыг бууруулах боломжит хувилбарыг боловсруулахад энэхүү зардлын тайлангийн зорилго оршино.

“Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн харилцан хяналт-тэнцлийг хангах үүднээс Улсын Их Хурал(цаашид, УИХ)-ын гишүүний тоог шинэчлэн тогтоох, УИХ-ын сонгуулийн дэвшилтэт тогтолцооны зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулах асуудлыг судлан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Энэ хүрээнд Улсын Их Хурлын 2022 оны 34, 54 дүгээр тогтоол, “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын зөвлөмжийг баримтлан Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг дараах агуулгын дагуу боловсруулсан байна. Үүнд:

- Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг: Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар, далан зургааг пропорциональ системээр сонгоно.
- Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэг: Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд заасан иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана.
- Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн дээд байгууллагууд” гэснийг “төрийн эрх барих дээд байгууллага” гэж, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “томилно” гэснийг “томилох бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглоно” гэж, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр” гэснийг “Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр Үндсэн хуулийг зөрчсөн тухай” гэж өөрчлөх.
- Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр¹ зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцох гэсэн өөрчлөлт оруулсан байна.

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн 21.1 болон 66.1 дэх хэсэгт холбогдох зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу хийсэн болно.

Энэхүү зардлын тооцооны тайлан нь дараах үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. УИХ-ын гишүүдийн тоог нэмэхтэй холбоотой зардлын тооцоо;

2. Үндсэн хуулийн цэц “тодорхой хяналт”¹ хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын тооцоо.

II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

2.1. УИХ-ын гишүүдийн тоог нэмэхтэй холбоотой гарах зардал

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Төрийн байгууллагын бүтэц бүрэлдэхүүн, зардал, ажлын ачаалалд нөлөө үзүүлэх боломжтой зохицуулалтыг сонгож авлаа.

Хүснэгт 1. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын зардалд нөлөөлөх зүйл заалт

Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэх холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт	Чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага
<i>Монгол Улсын Үндсэн хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</i> 1/Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг: “1.Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар, далан зургааг пропорциональ системээр сонгоно.”	<i>Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйл.</i> 2.Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. <i>Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйл.</i> 1.Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ. 2.Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа далан таваас доошгүй ажлын өдөр чуулна.	Улсын Их Хурал

УИХ-ын 76 гишүүнийг мажоритар, 76 гишүүнийг пропорциональ системээр сонгох бөгөөд нийт гишүүний тоо 152 байхаар хуулийн төсөлд тусгагджээ. УИХ-ын гишүүдийн тоо нэмэгдэхтэй холбоотой дараах 3 төрлийн зардал гарна гэж үзлээ. Үүнд:

¹ Concrete review.

- Сонгуулийн пропорциональ системээр сонгууль зохион байгуулахтай холбоотой зардал;
- Шинээр нэмэгдэх 76 гишүүнд олгох цалин хөлс, тусгай хангамж, томилолт болон бусад зардал;
- Нэмэгдсэн УИХ-ын гишүүдийн зөвлөх, туслах, биет төлөөлөгчийн цалин хөлс, бусад зардал.

2.1.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг нарийн тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

Гэвч Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн холбогдох зохицуулалт нь суурь зохицуулалт бөгөөд дээрх өөрчлөлт батлагдах тохиолдолд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл дэх сонгуулийн тогтолцоотой холбоотой төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг нарийвчлан тодорхойлоогүй болно. Өөрөөр хэлбэл, “УИХ-ын сонгуулийг зохион байгуулах” гэсэн үндсэн чиг үүргийн хүрээнд зарцуулах хугацаа, зардлыг ерөнхийлөн тооцов.

Хүснэгт 2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
УИХ-ын сонгуулийг холимог тогтолцоогоор зохион байгуулах	Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан чиг үүргийг СЕХ хэрэгжүүлэх /Хүсэлтийг бүртгэх, сонгуульд оролцох эрх олгох, саналын хуудас бэлтгэх, санал хураалтын дүн гаргах гэх мэт/
УИХ-ын нэмэгдсэн 76 гишүүн хуульд заасан ажил үүргээ гүйцэтгэх	Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх /хууль санаачлах, чуулган, байнгын хорооны ажлын хэсэгт ажиллах, хуралд оролцох гэх мэт/
УИХ-ын гишүүн хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх	УИХ-ын гишүүний зөвлөх, туслах, биет төлөөлөгч хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэх

2.1.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно.

УИХ-ын сонгуулийг пропорциональ системээр зохион байгуулах чиг үүргийг Сонгуулийн Ерөнхий Хороо(цаашид, СЕХ) сонгуулийн жил бүр нэг удаа гүйцэтгэхээр байна. Тухайлбал, сонгуульд оролцох намыг бүртгэх, намын жагсаалтад орох нэр дэвшигчийг бүртгэх, мэдээлэх, саналын хуудас бэлтгэх, санал хураалтын дүнг тоолох, дүн гаргах, мэдээлэх гэх мэт чиг үүргүүдийг гүйцэтгэх хугацаа нэмэгдэх төлөвтэй байна. Сонгуулийн тойрог нэмэгдэхгүй тул сонгуулийн тойрог дахь хэсгийн хороодын ажлын ачаалал нэмэгдэхгүй гэж үзэв. Сонгуулийн Ерөнхий Хорооны даргын 2013 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолоор СЕХ-ны ажлын алба нь 18 албан хаагчаас бүрдэнэ. Иймд тохиолдлын тоог 18 гэж тооцов.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9.1-т “Улсын Их Хурал ээлжит сонгуулийг сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө товлон зарлаж, санал авах өдрийг тогтооно” гэж, 9.2-т “Ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын сүүлийн хагасын аль нэг ажлын өдөр байна” гэж заасныг тус тус үндэслэн ээлжит сонгуулийн товыг зарласнаас сонгуулийн өдөр хүртэлх хугацаа буюу 4 сарын хугацаанд гүйцэтгэх чиг үүрэг буюу ажил, үйлчилгээний ачаалал нэмэгдэнэ гэж үзэв. Сард ойролцоогоор ажлын 22 гэж тооцон, 42,240 минутын ачаалал нэмэгдэнэ гэж тооцоолов.

Харин УИХ-ын гишүүн хуульд заасан чиг үүрэг гүйцэтгэх тохиолдлыг нэмэгдэх гишүүдийн тоогоор буюу 76 гэж, түүнд дэмжлэг үзүүлэх чиг үүргийн тохиолдлын тоог 1 гишүүнд орон тооны 1 туслах, 1 зөвлөх, 2 биет төлөөлөгч, нийт 4 орон тооны албан хаагчтай гэж үзэж 304 гэж тооцооллоо. УИХ-ын гишүүн болон түүний орон тооны туслах, зөвлөх, биет төлөөлөгч хуульд заасан чиг үүргээ жилийн турш гүйцэтгэнэ гэж үзэж, 1 жилд ногдох цагийг 1.600 ажлын цаг буюу 96,000 минут гэж үзлээ.

Хүснэгт 3. Стандарт үйл ажиллагаа холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолд-лын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
УИХ-ын сонгуулийг холимог тогтолцоогоор зохион байгуулах	Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан чиг үүргийг СЕХ хэрэгжүүлэх /Нэр дэвших хүсэлтийг бүртгэх, сонгуульд оролцох эрх олгох, саналын хуудас бэлтгэх, санал хураалтын дүн гаргах гэх мэт/	42,240	18	760,320

Улсын Их Хурлын нэмэгдсэн 76 гишүүн хуульд заасан ажил үүргээ гүйцэтгэх	Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх /хууль санаачлах, чуулган, байнгын хорооны ажлын хэсэгт ажиллах, хуралд оролцох гэх мэт/	96,000	76	7,296,000
Улсын Их Хурлын гишүүн хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх	Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслах, биет төлөөлөгч хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэх	96,000	304	29,184,000
Нийт				37,240,320

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1.600 ажлын цаг буюу (1.600 x 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 4. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
СЕХ-ны ажлын алба	760,320	96.000	7.92
УИХ	7,296,000	96.000	76
УИХ-ын гишүүний туслах, зөвлөх, биет төлөөлөгч	29,184,000	96.000	304

УИХ-ын гишүүдийн тоог нэмэх, ингэхдээ сонгуулийн пропорциональ аргыг хэрэглэхтэй холбоотойгоор 382 албан хаагчийг нэмэгдүүлэх шаардлага үүсэхээр байна. Үүнд, 76 гишүүн, түүний зөвлөх, туслах, биет төлөөлөгч гэх 304 албан хаагч багтах бөгөөд пропорциональ

системээр сонгууль зохион байгуулахад СЕХ-ны ажлын албанд нэмэлтээр 2 албан хаагчийн орон тоо шаардлагатай болно.

Нэмэгдэх ачаалал нь гагцхүү Үндсэн хуульд оруулах өөрчлөлттэй холбоотой шууд үүсэх ажлын ачаалал юм. Үндсэн хуульд оруулах өөрчлөлт батлагдах тохиолдолд Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэх ба уг нэмэлт, өөрчлөлтийн хүрээнээс хамаарч улсын төсөвт бусад шууд бус зардал нэмэгдэнэ. Тухайлбал, Байнгын хорооны тоо нэмэгдэх тохиолдолд түүнд холбогдох чиг үүргийг гүйцэтгэх ажлын алба, албан хаагчдын ачаалал нэмэгдэхийг дурдах нь зүйтэй.

Өөрөөр хэлбэл, УИХ-ын гишүүдийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор шууд зардал гарахаас гадна УИХ-ын тамгын газар, албан хаагчдын ачаалал шууд бусаар нэмэгдэхийг анхаарвал зохино.

2.1.3. Гаргах зардлыг урьдчилан тооцох

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн улмаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардал-г юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

СЕХ-ны албан хаагчдын жилийн дундаж цалинг 11,100,204 төгрөг гэж тооцлоо. Түүнд ногдох НДШ (12.5 хувь) нь **1,387,525.5** төгрөг. Иймд, 1 ажилтанд ногдох нийт цалингийн зардал нь **12,487,729.5** төгрөг байна.

УИХ-ын гишүүний жилийн дундаж цалин хөлс нь 24,000,000 төгрөг байна. Түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал нь 3,000,000 төгрөг байна. Мөн түүний туслах², зөвлөх³, биет төлөөлөгч⁴ зэрэг албан хаагчийн цалин хөлс нь дунджаар жилд 24,000,000.00 төгрөг байна. Түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал нь 3,000,000 төгрөг байна.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 5. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
СЕХ-ны ажлын алба	7.92	12,487,729.5	98,902,817.64
УИХ	76	27,000,000.00	2,052,000,000

² Туслахын сарын дундаж цалин 2 сая.

³ Зөвлөхийн сарын дундаж цалин 2 сая 200 мянга.

⁴ Биет төлөөлөгчийн сарын дундаж цалин 1 сая 800 мянга гэж тооцоолсон болно.

УИХ-ын гишүүний туслах, зөвлөх, биет төлөөлөгч	304	27,000,000.00	8,208,000,000
Нийт			10,358,902,817.64

2.1.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Улсын төсвөөс 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч буюу УИХ-ын даргад 62 тэрбум 880 сая төгрөгийн зардлыг төсөвлөсөн байна. Нарийвчлан үзвэл, УИХ-ын нийт төсвийн 60,765.6 нь урсгал зардал, 2,114.5 нь хөрөнгийн зардлаас бүрдэнэ.

Гишүүний тоо нэмэгдэхтэй холбоотойгоор хамгийн багадаа тэдгээр гишүүдийн ажлын байр, компьютер тоног төхөөрөмж, түүний туслах, зөвлөх, биет төлөөлөгчийн ажлын байр, компьютер тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал нэмэгдэнэ. УИХ-ын төсвийн зарцуулалтын задаргаа нээлттэй биш байх тул Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, нэмэгдсэн гишүүдийн ажлын байр, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 6. УИХ-ын гишүүн (туслах, зөвлөх, биет төлөөлөгч) -ий тоо нэмэгдэхтэй холбоотой материаллаг зардал/

Зардлын төрөл	Зардлын нэр	Зардал /төгрөгөөр/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	124,000
	Ном, хэвлэл авах	54,745
	Шуудан холбоо	306,812
	Компьютер, тоног төхөөрөмж	2,500,000
	Тавилга, эд хогшил	1,000,000
Зардал	Түлш, халаалт	263,408
	Гэрэл, цахилгаан	128,239
	Цэвэр, бохир ус	599,438
	Урсгал засвар	127,752

	Газрын төлбөр	22,253
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	300,000
	Тавилга, эд хогшил	100,000
<i>1 УИХ-ын гишүүн (туслах, зөвлөх, биет төлөөлөгчид гарах материаллаг зардал)</i>		5,526,647
<i>Нийт нэмэгдэх орон тоонд гарах материаллаг зардал</i>		2,100,125,860.00

УИХ-ын сонгуулийг пропорциональ системээр зохион байгуулахтай холбоотойгоор саналын хуудасны хэвлэлтийн зардал нэмэгдэнэ. УИХ-ын аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль, Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд 1 сонгогч 1 саналын хуудсыг бөглөсөн. Зардлын хувьд 1 саналын хуудсыг 1452-1485 төгрөгөөр хэвлэсэн байна. УИХ-ын 2020 оны сонгуулиар саналын хуудас хэвлүүлэхэд **3,104,321,220** төгрөгийн зардал гарч байжээ. Сонгуулийн пропорциональ аргад шилжих тохиолдолд саналын хуудасны хэмжээг томруулах шаардлага үүснэ. Урьдчилсан байдлаар саналын хуудасны хэвлэлтийн зардал хамгийн багадаа 3 дахин нэмэгдэхээр байна.

Хүснэгт 7. Холимог тогтолцоотой холбоотой саналын хуудасны зардал буюу бусад зардал

№	Бусад зардал		Төсөв
1	Саналын хуудас хэвлүүлэх, хамгаалах, хүргүүлэх зардал	2.1. Саналын хуудас хэвлүүлэх	9,312,963,660

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 8. Нийт зардал

Төрөл	Хүний нөөцийн зардал	Материаллаг зардал	Бусад зардал
Нийт Зардлын хэмжээ	10,358,902,817.64	2,100,125,860.00	9,312,963,660
Нийт зардал			21,771,992,337.64

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд төрийн байгууллагад ойролцоогоор **21,771,992,337.64** төгрөгийн зардал гарахаар байна. Түүнчлэн, энэхүү зардлын тооцоонд

тусгаагүй боловч нэмэгдсэн гишүүд, тэдгээрийн зөвлөх, туслах, биет төлөөлөгчийн ажлын байр болон тойргийн төсөв гэх мэт зардал нэмэлтээр гарна. Үүнээс хүний нөөцийн зардал болох 10 тэрбум 358 сая жил бүр, бусад зардал болох 9 тэрбум 312 сая төгрөг сонгуулийн жил бүр учирна. Харин материаллаг зардалд эхний жил 2 тэрбум 100 сая төгрөг зарцуулж, цаашлаад материаллаг зардлын хэмжээ буурна гэж үзлээ.

2.2. Үндсэн хуулийн цэц хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын тооцоо

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтөд тусгаснаар Үндсэн хуулийн цэц нь дараах 2 тохиолдолд маргааныг магадлан шийдвэрлэнэ. Үүнд:

- Үндсэн хуульд заасан иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр,
- УИХ, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр.

Хүснэгт 9. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын зардалд нөлөөлөх зүйл заалт

Холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт	Чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага
66.1. Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд заасан иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана.	Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэнэ.	Үндсэн хуулийн цэц
66.2. Үндсэн хуулийн цэц нь Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна.		

2.2.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтлах ёстой. Үүнд

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг нарийвчлан тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүргийг голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов.

Хүснэгт 10. Төрийн байгууллагын гүйцэтгэх ажил болон стандарт үйл ажиллагаа

Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн иргэний өргөдлийг шийдвэрлэх	Иргэний өргөдлийг хүлээн авах
	Өргөдлийг цэцийн дарга уг асуудлыг хянан шалгах гишүүнд хуваарилах
	Үндсэн хууль зөрчсөн тухай иргэнээс гаргасан өргөдлийг хүлээн авсан гишүүн анхны шалгалтыг 14 хоногийн дотор хийж маргаан үүсгэх эсэхийг өөрийн санаачилгаар шийдвэрлэнэ.
	Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаарх Цэцийн гишүүний шийдвэрийг маргагч талууд эс зөвшөөрч гомдол бичгээр гаргасан бол Цэцийн даргын тогтоолоор томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан хэлэлцэж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэж магадлал гаргана.
	Цэцийн хуралдаанд бэлтгэх
	Цэцийн хуралдааныг зарлах
	Цэцийн хуралдаанд маргаан хянан хэлэлцэх
	Цэц шийдвэр гаргахаар зөвлөлдөх, шийдвэр гаргах
	Нийтэд нэн даруй мэдээлэх
	Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтийг шууд хүлээн авах
Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан хүсэлтийн дагуу маргааныг хянан шийдвэрлэх	Цугларсан бичиг баримтад үндэслэн Цэцийн хуралдааны шийдвэрийн тэмдэглэх, тодорхойлох хэсгийн төслийг бэлтгэх
	Цэцэд хандах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан хүсэлтийг хүлээн авсан Цэцийн гишүүн маргаан шууд үүсгэж шалгана.
	Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаарх Цэцийн гишүүний шийдвэрийг маргагч талууд эс зөвшөөрч гомдол бичгээр гаргасан бол Цэцийн даргын тогтоолоор томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан хэлэлцэж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэж магадлал гаргана.
	Цэцийн хуралдаанд бэлтгэх
	Цэцийн хуралдааныг зарлах
	Цэцийн хуралдаанд маргаан хянан хэлэлцэх
	Цэц шийдвэр гаргахаар зөвлөлдөх, шийдвэр гаргах
	Нийтэд нэн даруй мэдээлэх

2.2.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу хийгдэх ажил, үйлчилгээгээр баримжаалж тогтоосон болно.

Дурдсан чиг үүргийн **тохиолдлын тоог** тогтоох боломжтой гэж үзэв. Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн иргэний өргөдлөөр маргаан хянан шийдвэрлэгдэх тохиолдлын тоог тооцохдоо Улсын Дээд шүүх(цаашид, УДШ)-ийн 2022 оны маргаан шийдвэрлэсэн статистик тоог баримталлаа. Үүнд:

Хүснэгт 11. УДШ-ийн хэрэг маргаан шийдвэрлэсэн тоон үзүүлэлт /2022 он/

	Эрүүгийн хэрэг	Иргэний хэрэг	Захиргааны хэрэг
УДШ-д ирсэн гомдлын тоо	1108	2701	550
УДШ-ээс хянан шийдвэрлэсэн маргааны тоо	431	1,652	190
Тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн тохиолдлын тоо	37	401	16

Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн иргэн нь Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргахаас өмнө эрхээ сэргээлгэхээр бүх шатны шүүхийн механизмыг ашигласан байхыг шаардана. Иймд УДШ-ээс иргэний гомдлыг хүлээн авч, хянан хэлэлцээд тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн тоогоор Үндсэн хуулийн цэцийн иргэний өргөдлийг хянан шийдвэрлэх чиг үүргийн тохиолдлын тоог тооцов. УДШ-ээс 2022 онд 4,359 гомдлыг хүлээн авснаас 454 тохиолдолд нь тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн байна. Цэцийн хяналтын загвар өөрчлөгдсөнөөр дээрх тооны гомдлыг өргөдөл хэлбэрээр Үндсэн хуулийн цэц хүлээн авна гэж үзлээ.

Иргэнээс ирүүлсэн өргөдөл бүрт холбогдуулан маргаан үүсгэдэггүй тул маргаан үүсгэх магадлалыг дараах тоон мэдээлэлд үндэслэн тогтоов. Үүнд:

Хүснэгт 12. Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мэдээлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийн тоон мэдээ /2018-2022 он/

№	Төрөл	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1.	Гомдол ⁵	33	45	37	23	36

⁵ Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаархи Цэцийн гишүүний шийдвэрийг маргагч талууд эс зөвшөөрч гомдол бичгээр гаргасан бол Цэцийн даргын тогтоолоор томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан хэлэлцэж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэж магадлал гаргана.

2.	Мэдээлэл	174	137	121	133	97
3.	Өргөдөл	28	64	31	28	54
6.	Хүсэлт	4	2	-	3	-
	Нийт:	237	248	189	187	187

Хүснэгт 13. Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдөл, мэдээлэл, гомдлыг тамгын газраас буцаасан байдлын тоон мэдээ

№	Өргөдөл, мэдээллийг буцаасан байдлын тоо
2022	46
2021	47
2020	46
2019	45
2018	29

Хүснэгт 14. Үндсэн хуулийн цэцийн гишүүний маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан тогтоолын тоон мэдээ

№	Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоолын тоо
2022	64
2021	72
2020	84
2019	91
2018	94

Дээрх статистикаас дүгнэвэл, Үндсэн хуулийн цэц жилд дунджаар 192 өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авдгаас ойролцоогоор 43-ыг буцааж, 81-т нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэхээс татгалздаг байна. Өөрөөр хэлбэл, нийт өргөдлийн 35 хувийг хүлээн авч шийдвэрлэдэг.

Иймд УДШ-ээс магадлал, шийдвэрийг хэвээр үлдээсэнтэй холбоотойгоор 454 иргэн Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргана гэж үзвэл, Үндсэн хуулийн цэц түүний 35 хувийг буюу 159 хэрэг шийдвэрлэнэ гэж тооцооллоо.

Харин эрх бүхий байгууллагын хүсэлтээр Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг шийдвэрлэх тохиолдлын тоог тогтоохдоо Хүний эрхийн комиссын 2020, 2021, 2022 оны тайланг үндэслэв. Хүний эрхийн комисс нь 2022 онд нийт 904 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 790-г шийдвэрлэж, түүний 2-т нь иргэнийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. 2021 онд 1146 гомдол хүлээн авснаас 1032-г шийдвэрлэж хариу өгч, түүний 2-т нь шүүхэд нэхэмжлэл гаргасан. 2020 онд 790 гомдлыг хүлээн авч, 715-г шийдвэрлэж, үүний 2-т нь шүүхэд нэхэмжлэл гаргасан. Иймд Хүний эрхийн комиссын хүсэлтээр Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэх тохиолдлын тоог 2 гэж тооцлоо. Үүн дээр бусад эрх бүхий албан тушаалтнаас жилд дунджаар 2 хүсэлт ирнэ гэж тооцоолж, хүсэлт шийдвэрлэх тохиолдлын тоог 4 гэж үзлээ.

Хүснэгт 15. Стандарт үйл ажиллагаа холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн иргэний өргөдлийг шийдвэрлэх	Иргэний өргөдлийг хүлээн авах	480	454	217,920
	Өргөдлийг цэцийн дарга уг асуудлыг хянан шалгах гишүүнд хуваарилах	960	454	435,840
	Үндсэн хууль зөрчсөн тухай иргэнээс гаргасан өргөдлийг хүлээн авсан гишүүн анхны шалгалтыг 14 хоногийн дотор хийж маргаан үүсгэх эсэхийг өөрийн санаачилгаар шийдвэрлэнэ.	4,800	454	2,179,200
	Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаарх Цэцийн гишүүний шийдвэрийг маргагч талууд эс зөвшөөрч гомдол бичгээр гаргасан бол Цэцийн даргын тогтоолоор томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан хэлэлцэж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэж магадлал гаргана.	4,800	159	763,200
	Цэцийн хуралдаанд бэлтгэх	10,560	159	1,679,040
	Цэцийн хуралдааныг зарлах	480	159	76,320
	Цэцийн хуралдаанд маргаан хянан хэлэлцэх	5,760	159	915,840

	Цэц шийдвэр гаргахаар зөвлөлдөх, шийдвэр гаргах	960	159	152,640
	Нийтэд нэн даруй мэдээлэх	960	159	152,640
Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан хүсэлтийн дагуу маргааныг хянан шийдвэрлэх	Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтийг шууд хүлээн авах	120	8	960
	Цугларсан бичиг баримтад үндэслэн Цэцийн хуралдааны шийдвэрийн тэмдэглэх, тодорхойлох хэсгийн төслийг бэлтгэх	480	4	1,920
	Цэцэд хандах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан хүсэлтийг хүлээн авсан Цэцийн гишүүн маргаан шууд үүсгэж шалгана.	960	4	3,840
	Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаарх Цэцийн гишүүний шийдвэрийг маргагч талууд эс зөвшөөрч гомдол бичгээр гаргасан бол Цэцийн даргын тогтоолоор томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан хэлэлцэж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэж магадлал гаргана.	4,800	4	19,200
	Цэцийн хуралдаанд бэлтгэх	480	4	1,920
	Цэцийн хуралдааныг зарлах	960	4	3,840
	Цэцийн хуралдаанд маргаан хянан хэлэлцэх	4,800	4	19,200
	Цэц шийдвэр гаргахаар зөвлөлдөх, шийдвэр гаргах	4,800	4	19,200
	Нийтэд нэн даруй мэдээлэх	10,560	4	42,240

Нийт	6,684,960
-------------	------------------

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /хөдөлмөрийн хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1.600 ажлын цаг буюу (1.600 x 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 16. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Байгууллага	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Үндсэн хуулийн цэц	6,684,960	96.000	69.5

Үндсэн хуулийн цэцийн хяналтын загвар өөрчлөгдсөнтэй холбогдуулан шаардлагатай хүний нөөцийн тоо 69 хүн байхаар байна. Одоогоор Үндсэн хуулийн цэц 9 цэцийн гишүүн, 3 бүртгэлийн ажилтан, 9 туслах буюу шинжээч, 1 шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, 5 судлаач, 1 хууль зүйн газрын дарга гэсэн, нийт 28 хүний бүрэлдэхүүнтэйгээр “хийсвэр хяналт”-ыг хэрэгжүүлдэг. Иймд хийсвэр хяналтын чиг үүргийг гүйцэтгэхэд оролцдог 28 хүнийг хасвал, Үндсэн хуулийн цэцээс тодорхой хяналт хэрэгжүүлэхэд 41 албан хаагч нэмэлтээр шаардлагатай гэж үзлээ. Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн тоо өөрчлөгдөхгүй тул 41 хүнийг Үндсэн хуулийн цэцийн бусад “албан хаагч” гэж үзэв. Бусад “Албан хаагч” гэдэгт иргэн, эрүү, захиргааны хэргээр мэргэшсэн зөвлөх туслах, шинжээч, бүртгэлийн ажилтан, судлаач зэргийг ойлгоно.

2.2.3. Гаргах зардлыг урьдчилан тооцох

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн улмаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардал-г юун түрүүнд тооцно.

Үндсэн хуулийн цэцийн албан хаагчдад зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай.

Үндсэн хуулийн цэц маргаан хянан шийдвэрлэхэд бүртгэлийн ажилтан, шүүхийн хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, судлаач зэрэг бусад албан хаагч оролцдог. Тэдгээр албан хаагчид нь Засгийн газрын 2020 оны 75 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээ”-ээр цалинждаг. Уг

цалингийн сүлжээг үндэслэн тэдгээр албан хаагчдын дундаж цалинг 1,500,000 төгрөг гэж үзвэл нэг жилд 18,000,000 төгрөг, түүний НДШ зардалд 2,250,000 төгрөг, нийт 20,250,000 төгрөг зардал гарна гэж тооцооллоо.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 18. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Төрийн байгууллага	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
Үндсэн хуулийн цэцийн бусад албан хаагч	41	20,250,000	830,250,000
Нийт			830,250,000

2.2.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, Материаллаг дундаж зардал, Бусад зардлыг нэмснээр нийт зардал илэрхийлэгдэнэ.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардлууд орно.

Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, нэмэгдсэн ажлын байранд оногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 19. Нэг албан хаагчид оногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	Зардал /төгрөгөөр/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	124,000
	Ном, хэвлэл авах	54,745
	Шуудан холбоо	306,812
	Компьютер, тоног төхөөрөмж	2,500,000
	Тавилга, эд хогшил	1,000,000
Зардал	Түлш, халаалт	263,408
	Гэрэл, цахилгаан	128,239
	Цэвэр, бохир ус	599,438
	Урсгал засвар	127,752

	Газрын төлбөр	22,253
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	300,000
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид оногдох		5,526,647
Нийт		226,592,527

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 20. Нэг албан хаагчид ногдох зардал

Төрөл	Хүний нөөцийн зардал	Материаллаг зардал	Бусад зардал
Нийт Зардлын хэмжээ	830,250,000	226,592,527	-
Нийт зардал			1,056,842,527

Үндсэн хуулийн цэцийн тодорхой хяналтыг хэрэгжүүлэх болсонтой холбоотойгоор хүний нөөцийн зардал нь 1,056,842,527 төгрөг гарч байна.

Хүснэгт 21.ҮХЦ-ийн сүүлийн 5 жилийн зарцуулалтыг тоймлон үзвэл,

Улсын төсвийн зарлага	2018	2019	2020	2021	2022
Үндсэн хуулийн цэцийн дарга /Төсвийн ерөнхийлөн захирагч/	2032.3	2693.8	2506.4	2453.9	2922

Үүнээс үзвэл, Үндсэн хуулийн цэцийн хяналтын загвар өөрчлөгдсөнөөр Үндсэн хуулийн цэцийн жилийн зардал нь ойролцоогоор 1 тэрбумаар ихсэж, 3.5-4 тэрбумд хүрэх төлөвтэй байна.

2.2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хувилбарыг нягтлах шатанд хуулийн төсөлд шинээр нэмэгдэж байгаа буюу өөрчлөгдөж буй зохицуулалттай холбоотой төрд үүсэх зардлыг хэрхэн багасгах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар боломж байгаа эсэхийг нягталж үзнэ.

Хувилбарыг нягтлах ажлыг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэнэ:

1. Стандарт үйл ажиллагааг цахимаар гүйцэтгэх боломжтой эсэх;
2. Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;
3. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх;
4. Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх;

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтөд тусгагдсан төрийн байгууллагын зардалд нөлөөлөх зохицуулалттай холбоотойгоор стандарт үйл ажиллагааг цахимаар хэрэгжүүлэх, мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах, мэдээллийн зарим агуулгаас татгалзах боломжгүй гэж үзлээ. Харин тохиолдлын тоог бууруулах буюу Улсын Их Хуралд нэмэгдэх гишүүдийн тоог бууруулсан тохиолдолд холбогдох зардал буурах боломжтой.

III ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцож, холбогдох зардлыг бууруулах боломжийг тодорхойлохыг зорилоо.

Нэг. УИХ-ын гишүүдийн тоог нэмэх зохицуулалттай холбоотой дараах зардал гарахаар байна. Үүнд:

- Пропорциональ системээр сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах зардал;
- Нэмэгдсэн УИХ-ын гишүүдэд ногдох цалин хөлс, томилолт болон бусад зардал;
- Нэмэгдсэн УИХ-ын гишүүний зөвлөх, туслах, биет төлөөлөгчийн цалин хөлс, бусад зардал.

УИХ-ын гишүүдийн тоог нэмэх, ингэхдээ сонгуулийн пропорциональ системээр сонгууль зохион байгуулахтай холбоотой 382 албан хаагчийн хүний нөөц хэрэгтэй бөгөөд үүнийг мөнгөн дүнд шилжүүлбэл 1,222,892,527 төгрөгийн зардал гарахаар байна.

Хоёр. Нэмэгдэх ачаалал нь гагцхүү Үндсэн хуульд оруулах өөрчлөлттэй холбоотой шууд үүсэх ажлын ачаалал юм. Үндсэн хуульд оруулах өөрчлөлт батлагдах тохиолдолд Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэх ба уг нэмэлт, өөрчлөлтийн хүрээнээс хамаарч улсын төсөвт шууд бусаар үүсэх бусад зардлууд нэмэгдэх магадлалтай. Тухайлбал, Байнгын хорооны тоо нэмэгдвэл, түүнд холбогдох чиг үүргийг гүйцэтгэх ажлын алба, албан хаагчдын ажлын ачаалал мөн нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл, гишүүдийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор УИХ-ын тамгын газрын зохион байгуулалт, албан хаагчдын ажлын ачаалал шууд бусаар нэмэгдэх магадлал байгааг анхаарах нь зүйтэй.

Боловсруулсан хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд төрийн байгууллагад багадаа **21,771,992,337.64** төгрөгийн зардал гарахаар байна. Түүнчлэн, энэхүү зардлын тооцоонд тусгаагүй боловч дараах зардал гарах төлөвтэй байна. Үүнд: нэмэгдсэн гишүүд, тэдгээрийн зөвлөх, туслах, биет төлөөлөгчийн ажлын байр болон тойргийн төсөв гэх мэт.

Гурав. Үндсэн хуульд заасан үндсэн эрх нь зөрчигдсөн иргэн нь Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргахаас өмнө эрхээ сэргээлгэх бүх шатны шүүхийн механизмыг ашигласан буюу УДШ-ээр маргаанаа шийдвэрлүүлсэн байхыг шаардана. Иймд УДШ 2022 онд 4,359 гомдлыг хүлээн авснаас 454 тохиолдолд нь тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн байх бөгөөд энэ 454 иргэн Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, гомдол гаргана гэж тооцооллоо.

Үндсэн хуулийн цэц дээрх тооны өргөдлийг хүлээн авч, түүний 35 хувьд нь маргаан үүсгэнэ гэж тооцоолоход Үндсэн хуулийн цэцийн ажлын ачаалал 41 албан хаагчийн тоотой тэнцэх хэмжээгээр нэмэгдэхээр байна. Үүнд ноогдох зардал нь ойролцоогоор 1 тэрбум 220 сая төгрөгөөр нэмэгдэхээр байна. Шалтгаан нь Үндсэн хуулийн цэцийн тодорхой хяналтыг хэрэгжүүлэх болсонтой холбоотойгоор Үндсэн хуулийн цэцэд хандах иргэдийн тоо нэмэгдэх бөгөөд хүний нөөцийг нэмэгдүүлэх шаардлага үүснэ.